

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЪЁГ

Д/д	Нэрс	Дэвшүүлсэн санал	Тусгасан байдал
1.	Д.Шүрэнтуяа /Циркийн салбарын ахмад ажилтан/	Олон Улсын уралдаан наадамд оролцоод, агаарт 6 эргээд дээд амжилт тогтоогоод олон Улсад амжилтаа үнэлүүлээд ирж байхад Монголд үүнийг үнэлэхгүй байна. Засгийн газар мөнгөн шагналыг олгохгүй байна. Энэ асуудлыг хуулийн төсөлд тусгах	Хуулийн төслийн 18.7-д “...Дэмжлэг үзүүлэх, мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар батлахаар тусгасан”
2.	Н.Уртнасан /Байгаль, соёлын өвийг хамгаалах сангийн тэргүүн/	Соёл, урлагийн салбарт хууль тогтоомж бол багадаагүй ээ. Харин түүнийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо бүрдэхгүй байна. Соёлын өвийг хадгалж хамгаалахад хамгийн гол зүйл бол мэдээж хүн хүч, хүний нөөцийн асуудал боловч хөрөнгө санхүүгийн дэмжлэг юм. Түүнээс энэ салбарт хууль тогтоомж хангалттай байгаа, Иймд соёлын өвийг хадгалж хамгаалахын тулд тусгайлан хөрөнгө хүч зарцуулахгүйгээр урагшаа явахгүй юм. Соёл, урлагийн хөгжүүлэх санд уг нь тийм ч их мөнгө орохгүй юм шүү дээ. Үүнд үндсэндээ 5 км хар зам тавьчих мөнгө л өгчих л дөө. Тэгэхэд энэ салбарын хүмүүс их юм хийнэ шүү. Иймд санхүүжилтээ л нэмчих. Үүнд л эхний ээлжид анхаармаар байна.	- Соёлын байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч соёлын эдийн засаг, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мэргэжлийн урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, түүнээс олсон нийт орлого нь санхүүжилтийн гол эх үүсвэр болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн. Соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотойгоор мерчандайзын гэрээний зохицуулалтыг тусгаж өгсөн.
3.	Ж.Жанчивдорж /Циркийн салбарын ахмад ажилтан/	Манай салбар хувьчлагдсаныг та бүхэн сайн мэдэж байгаа. Миний ойлгож байгаар хувьчлал 2 замтай гэж боддог. 1-т 100% хувьчлах гэдэг нэг асуудал, 2-т менежментийн хувьчлал гэдэг бас өөр асуудал юм. Гэтэл өнөөдөр монголын циркийг менежментийн хувьчлал хийсэн гэж байгаа. Тэр ажлын үр дүнг хянаж, тооцож үзсэн зүйл байна уу. Хэр оновчтой болсон юм бэ. Гэтэл өнөөдөр циркийн салбарыг төлөөлөөд явж байгаа бид болон энэ салбарын гудамжинд байгаа уран бүтээлчдийн нөхцөл байдлыг харахад ямар байна вэ гэдэг талаас боддог, санадаг, сэтгэл зүрх гаргадаг хүн, байгууллага, төр засаг гэж байна уу. Гадаадад тоглолтоор явахад зохицуулалтын асуудлыг тусгаж өгнө үү	Соёлын агентыг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, соёлын үйл ажиллагаан дахь хязгаарлалт, соёлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, хариуцлагын асуудлыг тусгасан.
4.	Б.Бямбабаяр /Хөгжмийн зохиолчдын холбооны тэргүүн/	Нэгт би оюутнуудад хөгжмийн хичээл заадаг байгаа. Хичээл дээр монгол ая аялгуу бүхий дууны талаар заахад оюутнууд өөдөөс бид зохиолын дуу сонсдоггүй гэж байна. Хоёрт миний 7 настай бяцхан охин Хөгжим бүжгийн дунд сургуульд сурдаг. Гэтэл телевиз үзэж байгаад би том болоод англи дуу зохионо гэж байна. Энэ 2 жишээг авч үзэхэд бидний хойч үе хүүхэд залуус монгол пентатоникийн 5 хөгт суурилсан монгол ая аялгуугаа сонсохгүй, дургүй, ойлгохгүй болж байна. үүнд юу нөлөөлсөн бэ гэхээр цэцэрлэг болон дунд	Хуулийн төслийн 15.1.1-д “төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”-аар заасан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Соёлын бодлогод Соёлын аюулгүй байдлын асуудлыг тусган шийдвэрлэхээр зохицуулсан.

		сургуульд олгож байгаа дуу, хөгжмийн хичээлийн хөтөлбөр агуулга хангалтгүй байгаагийн тод жишээ юм. Иймд үүнийг шинэчлэн сайжруулахад анхаараач ээ	
5.	Т.Дорждавга /МУИС-ийн зөвлөх профессор, соёлын филосифич/	Би соёлын хуультай холбогдуулан өөрийн бодол саналаа хэлэхийг хүсэж байна. Өнгөрсөн оны 8 дугаар сард соёлын тухай хуулийг хэрхэн авч үзэх, шинэчлэлийн асуудалд хэрхэн хандах талаар соёлын философич, судлаач хүний хувиар нэлээн урт нийтлэл бичиж, хэвлүүлсэн. Энэ материалтай уншиж танилцахыг хүсэн Соёл, урлагийн бодлогын газарт болон агентлагийн удирдлага мэргэжилтнүүдэд хэвлэж хүргүүлсэн байгаа. Түүнд юу гэж бичсэн бэ гэхээр “Соёл” гэдэг үг нь өөрөө маш өргөн үзэгдлийг илэрхийлсэн үг нэршил юм. Соёл гэж юу гэсэн үг вэ гэдэг хүн өөрөө хүн байх үзэгдэл үйл явцыг тодорхойлж байгаа юм. Иймээс энэ соёл, урлагийн бие даасан салбарын харилцааг зохицуулж байгаа ганц хууль болох соёлын тухай хууль нь нэр томъёоноосоо эхлээд оновчтой бус, эргэж харах ёстой зүйл гэдгийг би удаа дараа хэлж өгөөд байгаа юм. Энэ хуулийг шинэчлэн хийхдээ соёлын тухай хууль гэдэг нэрээ солих хэрэгтэй. Харин урлагийн тухай хууль гэж байх ёстой юм.	Соёл гэсэн орон зайд урлагийн асуудал нь хамаарах болон нийтэд хэвшсэн ойлголтын хүрээнд Соёлын тухай хуулийн гэж хуулийн төслийг боловсруулсан.
6.	Ж.Сэнгэдорж /Кино найруулагч/	Кино урлагийн салбарыг буцааж төрийн байгууллага болгож өгөөч гэх зүйл байхгүй бөгөөд цэвэр өрсөлдөөний дүнд хөгждөг учир бидэнд хашаа байшин хэрэггүй өөрөө өөрсдийг өө аваад явчихна. Гол нь бодлогын дэмжлэг л хэрэгтэй байна.	Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барьсан.
7.	М.Алтанцэцэг /МҮЭХ-ны төлөөлөл/	Соёлын салбарын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр дараах хэдэн саналууд байна. Үүнд: • Соёлын тухай хууль удааширч гацаж байгаа. Түүнд нэг ч том шалтгаан байгаа. Энэ нь соёлын ажилтны цалин, нийгмийн баталгаа, тэтгэмжийн асуудлаас болоод хойшлогддог юм. • Төрийн албаны тухай хууль соёл, урлагийн салбарт ээлгүй байна. үүнийг анхаарч өгнө үү. • Соёл, урлагийн ажилтны Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн нэмэгдлээс болон бүүр татвараас чөлөөлж өгнө үү. Яагаад гэвэл өнөөдөр соёлын ажилтны дундаж цалин 562,000 мян.төг байна. Гэтэл энэ татварын хууль үйлчилж эхэлснээр энэ дундаж цалин нь 496,000 мян.төг бол буурахаар тооцоо гарч байна. • Тэтгэвэрт гарах насыг чөлөөтэй болгомоор байна. Гарах нь гараад гарахгүй нь ажиллана биз.	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төрийн үйлчилгээний албан хаагч адил тэтгэмж авах зохицуулалт тусгагдсан тул Соёлын тухай хуулийн төсөлд тусгах шаардалгагүй болсон.

8.	С.Сүхбаатар /Үндэсний түүхийн захирал/ музейн	Манай музей 5 жилийн өмнө жилийн орлого 75,0 сая төгрөг байсан, гэтэл өнгөрсөн 2017 онд 263,0 сая төгрөгийн орлоготой ажилласан, бид төлөвлөгөөгөө 200% дахин давуулж биелүүлсэн байдаг. Энэ бол том боломж. Тийм учраас энэ боломжийг ашиглаад хүүхдүүдийг үнэгүй үзүүлдэг болмоор байна. Манайхаас бусад улсууд музейгээ үнэгүй үзүүлэх бодлого барьж байгаа, үүн дээр анхаарч өгнө үү.	Хуулийн төслийн 10.4-т “Музейн үйлчилгээнд 16 хүртэлх насны хүүхэд үнэ төлбөргүй хамрагдана. Музейн үйлчилгээнд үнэ төлбөргүй хамруулахад дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална” гэж заасан.
9.	О.Сундуй /Хүүхдийн зохиолч/	өнөөдөр хүүхдийн заавал унших ном, заавал үзэх кино гэсэн жагсаалт байх ёстой бол үүний санхүүжилтийн механизмыг нь давхар шийдэж өгөх хэрэгтэй байна. Учир нь тэр жагсаалтад байгаа ном нь тухайн нутаг дэвсгэрийн нийтийн номын сан болон сургуулийн номын санд нь байна уу, байхгүй бол тэгээд хаанаас олж унших вэ, энэ уялдаа холбоог бодлогоор хангах хэрэгтэй юм. Иймд жагсаалтад баталсан номоо улсаас номын сангуудад байршуулахад анхаарах хэрэгтэй.	Хуулийн төслийн 10.3-д “Боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад соёлын үйл ажиллагааны зарим чиглэлээр мэдлэг олгох заавал судлах уран бүтээлийн жагсаалтыг боловсролын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, 10.5-д “Орон нутгийн номын сан, орон нутаг судлах танхимын мэдээллийн үйлчилгээ нь 16 хүртэлх насны хүүхдэд үнэ төлбөргүй байна” гэж тус тус зааж саналыг тусгасан.
10.	А.Цэдэн-иш /Үндэсний Урлагийн Их театрын Уран сайхны удирдагч	- Хуулийн төсөлд тусган соёл, урлагийн байгууллагын удирдлагуудыг сэлгэж ажиллуулах тогтолцоонд шилжмээр байгаа юм. - Орон нутгийн театр чуулга, түүний үйл ажиллагаа, хүний нөөц гээд бүх зүйл нь өнөөдрийн цаг үе, мэргэжлийн урлагийн байгууллагын шаардлага стандартыг хангаж чадаж байна уу гэдгийг эргэж харах цаг болсон.	Хуулийн төслийн 19.1-д “Соёлын салбарын хүний нөөцийн бодлогыг Засгийн газар батална.” гэж заасан.
11.	Н.Баатаржав /Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Соёлын төвийн эрхлэгч/	Хуулийндаа заагаад соёлын төв ба соёлын ордон гэдэг байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь мэргэжлийн урлагийн байгууллага биш юм. Заримдаа соёлын байгууллага уу урлагийн байгууллага юм уу замбараагүй байна. Иймд стандарттай болгож өгмөөр байна.	Хуулийн төслийн 7.8.2, 7.8.3-т заасан.
12.	Ш.Эрдэнэцэцэг /Соёл, судлалын хүрээлэнгийн захирал/	Соёл, судлалын хүрээлэн нь СУИС-ийн дэргэд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус хүрээлэнд зарцуулах албан ёсны төсөв хөрөнгө байхгүй, хүрээлэнд харьяалж байгаа цөөхөн судлаачид нь оюутны төлбөрөөс цалинжиж байна. Өнөөдөр соёлын бодлого, хууль эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах талаар ярьж байна. Энэ шинэчлэлийг хийхийн тулд бодлогын суурь судалгаа манайд дутагдаж байгаа. Бид хүрээлэнгээ албан ёсны төсөвт байгууллагын статустай болгоод улсын захиалгаар судалгаа хийдэг, түүнд нь зориулсан төсөвтэй баймаар байна. Тэгэхгүй бол хүрээлэнгийн өнөөдрийг хүртэл явж ирсэн байдлыг харж үзэхэд тухайн хүрээлэнд харьяалж байгаа судлаач өөрийн хүсэл сонирхлын дагуу л хүссэн судалгаагаа хийж байна. Энэ нь улсад хэр ач	Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд зохицуулалтыг тусгасан.

		холбогдолтой зүйл юм бэ гэдгийг харж, бодлого төлөвлөгөөтэй болгомоор байна. Сайд энэ тал дээр онцгой анхаарч, соёл, урлагийн салбарын судалгаа, шинжилгээний ач холбогдлыг нэмэгдүүлэх, судлаачдыг бэлтгэмээр байна.	
13.	Ч.Алтангэрэл /Улсын филармоны гэрлийн техникч/	соёл, урлагийн салбарын хүний нөөцийг бэлдэх ажлын хүрээнд зөвхөн уран бүтээлчид биш тайзны ажилтан, гэрэл болон дууны техникчдийг мэргэжлийн түвшинд бэлтгэмээр байна.	Хуулийн төслийн 19.1-д “Соёлын салбарын хүний нөөцийн бодлогыг Засгийн газар батална” гэж заасан.
14.	Н.Наранбаатар Драмын Эрдмийн театрын ерөнхий найруулагч	Соёлын дархлааг бий болгох, бусад улсаас ялгарах арга нь урлаг соёл юм. Өөрийн соёл, урлагаар ирээдүйгээ бэлтгэе гэж үзэж байгаа бол телевизийн энэ олон замбараагүй сувгуудын заримыг хаах хязгаарлах, интернет, фэйсбүүкийг хаах, үүний дараа ард иргэдээ бүрэн гүйцэд боловсорсны дараа нээх хэрэгтэй байна. Ингээгүйгээс өнөөдөр хүмүүсийн араншин эвдэрч дуусаж байна. Энэ олон төр захиргааны байгууллагууд нэг бодлоготой баймаар байна. Яам, агентлаг, нийслэлийн соёл, урлагийн газар. Тэгвэл харьяа байгууллагуудад амар байна. Мөн хүүхэд залуучуудын театрыг байгуулах хэрэгтэй байна.	Хуулийн төслийн 15.1.1-д “төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”-аар заасан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Соёлын бодлогод Соёлын аюулгүй байдлын асуудлыг тусган шийдвэрлэхээр зохицуулсан.
15.	Д.Цэрэнсамбуу /Драмын эрдмийн театрын дарга/	Төрийн байгууллагын цалин хангамж, орчин нөхцөл тааруу тул гадаадад төгссөн авьяас чадалтай нь тогтохгүй хувийн хэвшил рүү гараад явчихдаг. Тэднийг хэрхэн тогтоож ажиллах механизм ямар байх уу? Соёл, урлагийн салбарын байгууллагуудын олж байгаа орлогыг өөрсдөд нь өгдөг болбол бид цалингаа нэмүүлэх гээд жагсаад цуглаад байх шаардлагагүй болно. Хийх ёстой ажлаа сайн хийчихнэ.	Соёлын байгууллагуудын өөрийн орлогыг тэглэж, Соёлын байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч соёлын эдийн засаг, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мэргэжлийн урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, түүнээс олсон нийт орлого нь санхүүжилтийн гол эх үүсвэр болгох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн. Соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотойгоор мерчандайзын гэрээний зохицуулалтыг тусгаж өгсөн.

